

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн
аудит

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/67/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2024 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jennisbekh@audit.gov.mn “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

БӨА-2024/67/НА-СТА-ТШЗ

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн
аудит

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн
аудит

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ЦЭНГЭЛ СУМЫН ХҮҮХДИЙН
2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Т.КУЛШАТ ТАНАА

2024.02.14 № 86
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд онцлох асуудал гараагүй байна.

Аудитын гол асуудал

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402131

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	78943962.00	147219509.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	49271738.00	115376995.00
31211	Төрийн сангийн харилцах	49271738.00	115376995.00
35	БАРАА МАТЕРИАЛ	29672224.00	31842514.00
354	Хангамжийн материал	29672224.00	31842514.00
35410	Бичиг хэргийн материал	128000.00	128000.00
35420	Аж ахуйн материал	27741224.00	31024014.00
35440	Түлш, шатах тослох материал	336000.00	240000.00
35460	Хүнсний материал	1467000.00	450500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1139960455.02	1544491567.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1139960455.02	1544491567.72
391	Газар	0.00	0.00
392	Биет хөрөнгө	1132290455.02	1536821567.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	1155709604.09	1553290877.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	-34710564.12	-59352788.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	24440930.00	38995409.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-15171764.95	-19033091.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29366840.00	53737600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-27344590.00	-30816439.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	5728000.00	5728000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5728000.00	-5728000.00
393	Биет бус хөрөнгө	7670000.00	7670000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7670000.00	7670000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1218904417.02	1691711076.72
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	796134.00	2693785.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	2693785.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1218108283.02	1689017291.72
51	Засгийн газрын хувь оролцоо	1218108283.02	1689017291.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7670000.00	7670000.00
51101	Өмч: - төрийн	7670000.00	7670000.00
51102	- хувийн	0.00	0.00
512	Хуримтлагдсан үр дүн	1152059858.34	1622968867.04
51210	Өмнөх үеийн үр дүн	1152059858.34	1152059858.34
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	470909008.70
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	58378424.68	58378424.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1218904417.02	1691711076.72

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,424,324,400.00	

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

			1,047,377,202.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	979,617,500.00	433,931,002.20
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	974,800,000.00	430,647,612.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	4,817,500.00	3,283,390.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	401,915,700.00	593,932,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	401,915,700.00	593,932,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,687,700.00	19,514,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,687,700.00	19,514,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	409,911,383.70	576,468,193.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	409,911,383.70	576,468,193.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	408,957,783.70	576,468,193.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	270,095,942.00	394,083,659.00
210101	Үндсэн цалин	233,303,517.00	293,669,082.00
210102	Нэмэгдэл	33,151,007.00	84,218,679.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	3,641,418.00	16,195,898.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,967,327.00	47,010,600.00
210201	Тэтгэврийн даатгал	26,083,027.00	32,733,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,970,700.00	3,851,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,377,100.00	2,780,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	594,100.00	694,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,942,400.00	6,951,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,354,074.00	21,371,785.00
210301	Гэрэл, цахилгаан	2,430,174.00	5,405,607.00
210302	Түлш, халаалт	15,423,900.00	14,780,178.00
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	1,186,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	150,000.00	-
210401	Бичиг хэрэг	150,000.00	-
2105	Нормативт зардал	57,054,726.00	67,233,300.00
210502	Хоол, хүнс	57,054,726.00	67,233,300.00

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	365,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	365,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	811,615.00	988,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	811,615.00	988,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,224,099.70	45,415,249.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,031,400.00	10,990,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,160,940.00	2,449,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,031,759.70	31,975,399.50
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	953,600.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	953,600.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,014,413,016.30	470,909,008.70
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,014,413,016.30	470,909,008.70

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	444706900.00	613446200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	401915700.00	593932200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	401915700.00	593932200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103500.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103500.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42687700.00	19514000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42687700.00	19514000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	393246162.00	541482043.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	393246162.00	541482043.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	392292562.00	541482043.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	270025382.00	394879793.00
210101	Үндсэн цалин	233232957.00	294465216.00
210102	Нэмэгдэл	33151007.00	84218679.00
210104	Урамшуулал	3641418.00	16195898.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37967327.00	47010600.00
210201	Тэтгэврийн даатгал	26083027.00	32733400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2970700.00	3851500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2377100.00	2780000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	594100.00	694700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5942400.00	6951000.00

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21383174.00	19214000.00
210301	Гэрэл, цахилгаан	3123174.00	3143822.00
210302	Түлш, халаалт	15760000.00	14684178.00
210303	Цэвэр, бохир ус	2500000.00	1386000.00
2105	Нормативт зардал	49603900.00	66216800.00
210502	Хоол, хүнс	49603900.00	66216800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300000.00	300000.00
210604	Урсгал засвар	300000.00	300000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	811615.00	988600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	811615.00	988600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12201164.00	12872250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7445274.00	10592850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4755890.00	2279400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	953600.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	953600.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	51460738.00	71964157.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2189000.00	5858900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2189000.00	5858900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-2189000.00	-5858900.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	49271738.00	66105257.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		49271738.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	49271738.00	115376995.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,670,000.00	58,378,424.68	1,152,059,858.34		1,218,108,283.02
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,670,000.00	58,378,424.68	1,152,059,858.34	0.00	1,218,108,283.02
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,670,000.00	58,378,424.68	1,152,059,858.34	0.00	1,218,108,283.02
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,670,000.00	58,378,424.68	1,152,059,858.34	0.00	1,218,108,283.02
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,670,000.00	58,378,424.68	1,152,059,858.34	0.00	1,218,108,283.02

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			470,909,008.70		470,909,008.70
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,670,000.00	58,378,424.68	1,622,968,867.04	0.00	1,689,017,291.72

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	662718000.00	547340943.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	662718000.00	547340943.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	662718000.00	547340943.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	493422200.00	394879793.00
210101	Үндсэн цалин	325565700.00	294465216.00
210102	Нэмэгдэл	154371100.00	84218679.00
210104	Урамшуулал	13485400.00	16195898.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60929600.00	47010600.00
210201	Тэтгэврийн даатгал	41432100.00	32733400.00
210202	Тэтгэмжийн даатгал	4874900.00	3851500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3899300.00	2780000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	974400.00	694700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9748900.00	6951000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19214000.00	19214000.00
210301	Гэрэл, цахилгаан	2254000.00	3143822.00
210302	Түлш, халаалт	14960000.00	14684178.00
210303	Цэвэр, бохир ус	2000000.00	1386000.00
2105	Нормативт зардал	68498600.00	66216800.00
210502	Хоол, хүнс	68498600.00	66216800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300000.00	300000.00
210604	Урсгал засвар	300000.00	300000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	988600.00	988600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	988600.00	988600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19365000.00	18731150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16399100.00	15765250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2965900.00	2965900.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	613446200.00	613446200.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	593932200.00	593932200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	593932200.00	593932200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	19514000.00	19514000.00
132001	Орон нутгийн төсвөөс	19514000.00	19514000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		49271738.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		115376995.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	28.00

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28.0	28.0
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	13.00	13.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00
650010	Гэрээт ажилтан	4.00	4.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь “Хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжих эрүүл таатай орчин бүрдүүлж, бүтээлч эвсэг хамт олон болох. Хүүхдийн сурлага, хүмүүжил, хөгжил, хүүхэд хамгааллын асуудлаар эцэг эхтэй хамтран ажиллах гэрээ байгуулж тэдний үүрэг хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккрузл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус цэцэрлэгийн 2023 оны үйл ажиллагаанд санхүү хяналт дотоод аудитаас шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 472.8 сая төгрөгөөр буюу 38.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	49271.7	115377.0	66105.3
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	29672.2	31842.5	2170.3
Үндсэн хөрөнгө	1139960.5	1544491.6	404531.1
Нийт хөрөнгө	1218904.4	1691711.1	472806.7
Өр төлбөр	796.1	2693.8	1897.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1218108.3	1689017.3	470112.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1218904.4	1691711.1	472806.7

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эцэст 115.4 сая төгрөг болж оны эхнээс 66.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүний 112.5 сая төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн, 0.6 сая төгрөг нь бараа үйлчилгээний бусад зардал, 2.3 сая төгрөг нь хүүхдийн хоолны зардлын төсвөөс үлдсэн мөнгө байна.

Бараа материал дансны үлдэгдэл оны эцэст 31.8 сая төгрөг болж 2.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аж ахуйн материал 31.0 сая төгрөг болж нэмэгдснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 404.5 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 5.8 сая, хөрөнгө оруулалтаар үнэгүй хүлээн авсан 430.5 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөд 32.0 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан цэцэрлэгийн барилга 397.6 сая, машин тоног төхөөрөмж 13.0 сая, тавилга эд хогшил 20.0 сая төгрөг хүлээн авсан байна.

Өглөг оны эцэст 2.7 сая төгрөг болж 1.9 сая төгрөгөөр нэмэгдсэн аудитын төлбөрийн нэхэмжлэх, гэрэл цахилгааны нэхэмжлэхтэй холбоотой гарсан тооцооны өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 470.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 470.1 төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 465.7 сая, орон нутгийн төсвөөс 19.5 сая, нийт зарлагыг 485.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас цэцэрлэгийн 2023 оны хувьсах зардлын төсвийг 481.3 сая төгрөгөөр хянаж, 15.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан ба төсвийн тодотголоор 112.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 593.9 сая төгрөг болгон тодотгож баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 19.5 сая төгрөгөөр баталж, тодотголоор өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 593.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 19.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 613.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 593.9 сая, орон нутгийн төсвөөс 19.5 сая нийтдээ 613.4 сая төгрөгийн санхүүжилт авч 49.3 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 547.3 сая төгрөг буюу 82.6 хувьтай буюу дансанд 115.4 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		/мянган төгрөгөөр/			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605	Эрүүл мэндийг дэмжих	1482.9	1482.9	0	100%
2	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	64142.6	61929.3	2213.3	96.5%
3	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	4055.8	4051.4	4.4	68.5%
4	81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	1482.9	942.0	540.9	63.5%
5	81832	Нүүдлийн бүлэгт хамруулах	17820.0	17107.3	712.7	96%
6	81834	Боловсролын стандарт, сургалтын	353583.4	294597.2	58986.2	83.3%
7	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	200636.4	147716.9	52919.5	73.6%
8	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	19514.0	19514.0	0	100%
Нийт дүн			662718.0	547341.0	115377.0	82.6%

Цэцэрлэгийн төсвийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс 115.4 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарчээ. Үүнд: цалингийн зардал 98.6 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 13.9 сая, бараа үйлчилгээний бусад зардал 0.6 сая, хүүхдийн хоолны зардал 2.3 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна”

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Цэцэрлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 88.2 сая төгрөгийн бараа материал, 5.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ний аудитор В.Хуандых гүйцэтгэж, анхан шатны хяналтыг “Уужим алтай Аудит” захирал Б.Галымбек, дараагийн шатны хяналтыг аудитын менежер Х.Женисбек, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 409.9 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 8.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%-тай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд 49.6 сая төгрөгийн алдаа¹ илэрч залруулга хийгдсэн. Үүнд: Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлогыг 49.6 сая төгрөгөөр илүү тайлагнасныг залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 22.4 сая төгрөгийн зөрчил² илэрч зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар цалингийн зардлаас ажилтнуудад 14.0 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Мэдээлэл технологийн үйлчилгээ 1.0 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх 1.5 сая, цалингийн зардал 1.3 сая, гэрэл цахилгааны зардал 3.2 сая, цэвэр бохир усны зардал 1.2 сая, хүүхдийн хоолны зардал 0.2 сая, нийт 8.4 сая төгрөгийн зардлыг тооцооны данс дамжуулан тооцоо хийгээгүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

3.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2, 20.2, 20.2.5 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж аливаа гүйлгээг тооцооны данс дамжуулан бүртгэж тайлагнах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан	1	49,571.4					1	49,571.4			
Дүн	1	49,571.4					1	49,571.4			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлаас ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1	14,000.0					1	14,000.0				
Зарим зардлыг тооцооны дансаар дамжуулан тооцоо хийгээгүй шууд зардлаар бүртгэсэн	1	8368.9					1	8368.9				
Дүн	2	22,368.9					2	22,368.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

Цэнгэл сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн
аудит

Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн									